



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 7 сарын 18 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт; Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2017 оны 06 дугаар сарын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Нягтлан бодох бүртгэлийн валютыг тогтоох, өөрчлөх, санхүүгийн тайланг хөрвүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх журмыг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар / Г.Түvdэндорж/-т үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Сангийн сайдын 2017 оны 7 сарын 18 өдрийн
219 тоот тушаалын хавсралт

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ВАЛЮТЫГ ТОГТООХ, ӨӨРЧЛӨХ, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХӨРВҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх валют /цаашид “бүртгэлийн валют” гэх-/ыг тогтоох, санхүүгийн тайланг бэлтгэх, хөрвүүлэн тайлagnахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын Монгол улсын Засгийн газартай байгуулсан гэрээнд энэхүү журамтай холбогдох асуудлаар тусгайлсан заалт байхгүй бол санхүүгийн тайлagnалдаа энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.3. Энэхүү журмаар зөвхөн нягтлан бодох бүртгэлийн стандартуудын нийцэл, санхүүгийн тайлagnалтай холбоотой асуудлыг зохицуулна.
- 1.4. Энэхүү журмаар аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах, тайлagnах, төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахгүй бөгөөд Монгол Улсын татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ татварын хуулийг мөрдлөг болгоно.

Хоёр. Бүртгэлийн валют

- 2.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөно.
- 2.2. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ гадаад валютаар хөтлөх зөвшөөрөл хүссэн албан бичгийг, дараах шалгуур үзүүлэлтүүдийг нэгээс доошгүй санхүүгийн жилд хангасан талаарх Аудитын тухай хуулийн 9.1.4-т заасан үйлчилгээний дүгнэлтийн хамт Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Үүнд:
 - 2.2.1. Борлуулалтын үнэ тогтооход нөлөөлдөг, нийт борлуулалтын 75 ба түүнээс дээш хувь нь тухайн валютаар хийгдэг эсэх;
 - 2.2.2. Борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардлын худалдан авалтын үнийг тогтооход нөлөөлдөг, эдгээр үзүүлэлтүүдийн нийт дүнгийн 75 ба түүнээс дээш хувийг тухайн валютаар гүйцэтгэдэг эсэх;
 - 2.2.3. Нийт санхүүжилтийн 90 хувийг бүрдүүлсэн валют мөн эсэх;
 - 2.2.4. Бүртгэлийн валютыг сонгоход хэрэглэсэн бусад хүчин зүйлс, нөхцөл байдлын талаар тодруулах;
- 2.3. Үндсэн үйл ажиллагаа, борлуулалт хийж эхлээгүй, бэлтгэл шатандаа байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хувьд энэ журмын 2.2-т заасан шалгуурыг үнэлэхдээ ирээдүйн төсөв, төсөөлөлд үндэслэн тооцоолж болно.
- 2.4. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон аудиторууд энэхүү журмын 2.2-т заасан шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэхдээ энэ журманд оруулсан дэс дарааллаар ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
- 2.5. Энэ журмын 2.2-т заасан аудитын дүгнэлтэнд дараахь зүйлсийн талаар нэмж тодруулна. Үүнд:

- 2.5.1. Санхүүгийн програм хангамжийн нэр, ажиллах горим, нягтлан бодох бүртгэлийг бүртгэлийн валютаас оор валютаар давхар хотлох боломжтой эсэх;
- 2.5.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь гадаадын аж ахуйн нэгжийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүрэлдчүүнд багтдаг охин компани бол толгой компанийн нэр, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүртгэлийн болон толилуулгын валютын талаарх мэдээлэл;
- 2.6. Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлөн авсан өдрөөс хойн ажлын 15 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 2.7. Гадаад валютаар бүртгэлийн валютаа тогтоосон аж ахуйн нэгж, байгууллага Стандартаар зовшөөрөгдсөн аргачлал, зарчмуудыг баримтлан нягтлан бодох бүртгэлээ төгрөгөөр давхар хотолж болно.

Гурав. Бүртгэлийн валютыг өөрчлох

- 3.1. Бүртгэлийн валютыг тодорхойлоход үндэслэл болгон хэрэглэсэн тохиол байдал өөрчлөгдсон ба сонгон хэрэглэж байсан бүртгэлийн валют мөнгөлийн үнэн зов байдлыг илрүүлж байсан үед бүртгэлийн валютыг өөрчилж болно.
- 3.2. Бүртгэлийн валютыг зовхон санхүүгийн жилийн эхинд өөрчилж болно.
- 3.3. Бүртгэлийн валютаа төгрөгөөс гадаад валют руу эсвэл нэг гадаад валютаас нөгөө гадаад валют руу өөрчлон тогтоож буй аж ахуйн нэгж, байгууллагууд энэ журмын 2.2-2.6-д заасны дагуу хүсэлтийг гаргаж, зовшөөрөл авна.
- 3.4. Гадаад валютаар нягтлан бодох бүртгэлээ хотлох зовшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлийн валютаа тогрог рүү өөрчлон тогтоож байгаа бол энэ талаар Санхүү, бүртгэлийн асуудал эрхлэсэн торийн захиргааны тов байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
- 3.5. Бүртгэлийн валютын өөрчлөлтийн үр нолоог ирээдүйд мөрдох горимыг ашиглан бүртгэнэ. Бүртгэлийн валютыг өөрчлон тогтоосон одроөр санхүүгийн тайлангийн бүх үзүүлэлтүүдийг тухайн одрийн валютын ханшаар хорвүүлнэ. Монгол бус зүйлсийн хорвүүлжин гаргасан дүнг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор түүхэн орлог төөнно.
- 3.6. Энэхүү журам баглагдахаас омни бүртгэлийн валютаа гадаад валютаар тогтоож, санхүүгийн тайлангаа хорвүүлжин гэж байсан бол энэ журмын 2 дугаар хэсэгт заасны дагуу зовшөөрөл авна. Энэ тохиолдолд бүртгэлийн валютаа гадаад валютаар тогтоохыг зовшөөрсөн шийдвэрийн дагуу энэ журмын 3.5-д заасан хорвүүлэлтийг гүйцэтгэхгүйгээр өмнө нь И-баланс програмд хорвүүлжин илгээсэн тайлангийн үндэгдлийг үргэлжлүүлжин хэрэглэнэ.

Дөрөв. Санхүүгийн тайланг бэлтгэх

- 4.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу тушаах санхүүгийн тайлангийн толилуулгын валиот зовхон үндэсний монгол тэмдэгт төгрөг байна.
- 4.2. Энэхүү журмын дагуу зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлийн буюу гадаад валютаар бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хоронго, ор толборийг хаалгын ханишаар, орлогын дэлгэрэнгүй тайлангийн (бусад дэлгэрэнгүй орлогоос бусад) үзүүлэлтүүдийг ажил гүйлгээ гарсан одрийн ханишаар, бусад зүйлсийг түүхэн ханишаар тус тус хөрвүүлэн тайлагнана.
- 4.3. Бүртгэлийн валиот оорчилсон жилийн зэрэгцүүлэгдх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг омно нь И-баланс програмд тушаасан санхүүгийн тайлангийн дүнгээр тайлагнана.